

УДИРДЛАГА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэл байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв		Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин /Эхний хагас жил/	Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
		Хэмжээ, сая.төг	Төсвийн эх үүсвэр					
УСНЫ ГАЗРЫН СТРАТЕГИЙН ЭРХЭМ ЗОРИЛГО: Усны талаарх хууль тогтоомж, бодлого хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, усны нөөцийн нэгдсэн менежментийн зарчмыг хэрэгжүүлэх, мэргэжил аргагүйн удирдлагаар хангах хангах, усны хэмнэлттэй, үр ашигтай хэрэглээг төлөвшүүлэхэд чиглэгдэнэ.								
НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН БОЛОН ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ								
Байгууллагын төлөвлөгөөний 1 дүгээр зорилт: Усны нөөцийг судалж тогтоох, усны нөөц, түүний сав газрыг хамгаалах, нөхөн сэргээх, хомстохоос урьдчилан сэргийлэх, хуримтлуулах, арвижуулах, усны сав газрын менежментийн тогтолцоог бэхжүүлэх, усны нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлнэ								
Зорилт 1. Гадаргын усны нөөцийг хомстохоос сэргийлэх, нөхөн сэргээх, арвижуулах, гадаргын ус хуримтлуулах төслийг төлөвлөн, хэрэгжүүлэх, хууль эрхзүй, үнэ тарифын орчныг сайжруулах								
1	Арга хэмжээ 1.1.Нэг сум-Нэг нуур /333 нуур/ хөтөлбөрийн хүрээнд баруун бүсийн гадаргын ус хуримтлуулах хөв цөөрөм байгуулах төсөл хэрэгжүүлэх	6,589.6	Улсын төсөв	Тендер сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан ажлын гүйцэтгэлийн хувь	-	42 хөв цөөрөм байгуулах төслийн тендер сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан байна.	Монгол улсын 2025 оны Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар Гадаргын ус хуримтлуулах, хөв цөөрөм байгуулах /Баруун бүс/ 6,589.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын арга хэмжээг баталсны дагуу БОУАӨЯ-ны шийдвэрээр худалдан авах ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны газраар гүйцэтгүүлж байна. Усны газрын зүгээс Ус ашиглалтын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Мягмаржав үнэлгээний хорооны гишүүнээр ажиллаж байгаа бөгөөд нийт 12 багц тендер зарлагдсанаас 4 багцад хамаарах 4 хөв цөөрмийн тендер сонгон шалгаруулалтыг хугацаанд нь зарлаж гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан ажлыг эхлүүлээд байгаа бол бусад 8 багц тендер нь анхны зараар оролцогч байгаагүй тул дахин тендер зарласан. Тендрийг 2025 оны 06 сарын 18-ны өдөр нээнэ. Нийт гүйцэтгэл 50 хувьтай байна.	100
				Батлагдсан ТЭЗҮ, зураг төсөл концепци	-	Нэг сум-Нэг нуур /333 нуур/ хөтөлбөрийн хүрээнд,ТЭЗҮ, зураг төсөл концепци албажуулах	Хөв цөөрөм, усан сан, усны хуримтлалыг бий болгох, газрын таарцын судалгааны мэдээллийг ALOS PASLAR хиймэл дагуулыг ашиглан боловсруулж тоон загварт үндэслэн "Монгол орны хөв цөөрмийн байршлын катологи"-ийг боловсруулан "Нэг нуур нэг сум" 333 нуур арга хэмжээ байдлаар БОУАӨ Сайдад танилцуулж, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар 42 хөв цөөрөм байгуулахаар төсөв батлагдсан. Үүнтэй холбоотойгоор 2025.04.03-ны өдөр "Төмөр бетон хийцтэй боомт бүхий хөв цөөрмийн жишиг зураг", "Шороон боомт ус халиах далан бүхий хөв цөөрмийн жишиг зураг"-нууд нь магадлалаар батлагдсан. Тендер сонгон шалгаруулалттай холбоотойгоор 2025.04.03-нд 5 багцын 38 хөв цөөрмийн ТЭЗҮ, 2025.04.14-нд 4 багцын 4 хөв цөөрмийн ТЭЗҮ тус тус батлагдаж, 100 хувийн гүйцэтгэлтэй байна.	
ХОЁРДУГААР ХЭСЭГ: ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ								
Байгууллагын төлөвлөгөөний 4 дүгээр зорилт: Салбарыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах, үйл ажиллагааны менежментийг боловсронгуй болгох, боловсон хүчний чадавхыг бэхжүүлэх, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, санхүү, хөрөнгө оруулалтыг төлөвлөж хэрэгжүүлэх, төсвийн санхүүжилтийг үр ашигтай зарцуулах, цахим санг бүрдүүлж, хууль эрхзүй, эдийн засгийн орчныг бүрдүүлж, хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх, эрсдэл, үр дүн, үр нөлөөг үнэлж, дүгнэлт өгөх.								
Зорилт 2.Салбарын удирдлагын манлайллыг хангах, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах, дотоод хяналт шинжилгээ үнэлгээ хийх								

2	Арга хэмжээ 2.1.Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, салбарын яам, сайдаас өгсөн ажлын чиглэлийг хэрэгжүүлэх			Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь	2024 онд 86 хувьтай хэрэгжүүлсэн	Бодлогын баримт бичиг, хууль тогтоомжоор хариуцуулсан болон эрх бүхий албан тушаалтаас ирүүлсэн чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж хариуг хүргүүлсэн байна.	"Алсын хараа 2050" урт хугацааны хөгжлийн бодлого /20 арга хэмжээ/, Монгол улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө /8 арга хэмжээ/, Шинэ сэргэлтийн бодлого /2 арга хэмжээ/, Монгол улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний төлөвлөгөө, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө /4 арга хэмжээ/ зэрэг бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан 21 чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, Алсын хараа 2050 хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн 2024 оны гүйцэтгэлийн нэмэлт тайланг 2025.04.25-нд БОУАӨЯ-ны БНБХГ-т цахимаар хүргүүлсэн. Мөн Хууль тогтоомж, тогтоол шийдвэртэй холбоотой 17 чиг үүргийн хэрэгжүүлж ажиллан тайланг 2025 оны I улирлын байдлаар гаргаж 2025.04.07-нд БОУАӨЯ-ны БНБХГ-т цахимаар хүргүүлсэн.	100
3	Арга хэмжээ 2.2.Ус ашиглуулах болон хаягдал усны дүгнэлт, зөвшөөрөл, гэрээний хэрэгжилтэд дотоод хяналт шалгалтыг хийх, Үндэсний аудитын газраас ирүүлсэн акт, албан шаардлагын хэрэгжилтэд дотоод аудит хийж, санал, дүгнэлт, зөвлөмж хүргүүлэх.			Дотоод аудитын төлөвлөгөөний гүйцэтгэлийн хувь	90 хувь	Дотоод аудитын төлөвлөгөөний дагуу эхний хагас жилийн хяналт шалгалтыг 80 хувь хийсэн байна.	Усны газар болон сав газруудын захиргаадын үйл ажиллагаанд "Дотоод аудитын ажлын баримт: "АБ1005" хүрээнд эрсдэлийн урьдчилсан үнэлгээ хийж дотоод аудитын дунд хугацааны төлөвлөгөөнд холбогдох хэлтсүүдээс санал авч "Дотоод аудитын дунд хугацааны төлөвлөгөө" боловсруулж агентлагийн даргын тушаалаар батлуулсан. Усны газар болон сав газруудын захиргаадын үйл ажиллагаанд Үндэсний аудитын газар болон хөндлөнгийн хяналт шалгалтын байгууллагаас ирүүлсэн акт, албан шаардлага, дүгнэлт зөвлөмжийн биелэлтийг "Төрийн аудитын тухай" хуульд заасны дагуу төлөвлөгөө гаргаж Үндэсний аудитын газарт хүргүүлэх, хэрэгжилтийг хангаж ажиллахад хяналт тавьж батлагдсан төлөвлөгөөний дагуу ажиллаж байна. Сав газруудын захиргаадаас иргэн аж ахуйн нэгж, байгууллагад гаргасан ус ашиглуулах дүгнэлт, холбогдох хууль дүрэм, журам, стандартын дагуу хийсэн байдлыг тулган баталгаажуулж, дотоод аудит хийж дүгнэлт зөвлөмж хүргүүлж, илэрсэн алдаа дутагдлыг арилгуулах арга хэмжээ авч Сав газрын захиргаадын албан хаагчдад зөвлөмж хүргүүлж, сургалт зохион байгуулсан.. 2025 оны байдлаар Туул голын сав газрын захиргаанаас гаргасан Ус ашиглуулах дүгнэлтэд газрын даргын баталсан дотоод аудитын удирдамжийн дагуу, дотоод аудит хийж гүйцэтгэсэн.	50

4	Арга хэмжээ 2.3.Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан нийтлэг журмын дагуу байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүдэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, БОУАӨЯ-д хүргүүлэх.			Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь	2024 онд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг БОУАӨЯ-д хүргүүлсэн	Холбогдох журмын дагуу эхний хагас жилийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, БОУАӨЯ-д хүргүүлсэн байна.	Монгол Улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүдэд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт, зөвлөмж боловсруулан ажилласан. Усны газрын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилт, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Байгууллагын ил тод байдлын үнэлгээ, Хууль тогтоомжийн биелэлтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн. Хяналт шинжилгээ үнэлгээний тайланг хуулийн хугацаанд буюу 2025 оны 1 дүгээр улиралд багтааж БОУАӨЯ-ны ХҮАГ-т тайлагнасан. Агентлагийн 2025 оны эхний хагас жилийн Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд Засгийн газрын "Журам батлах тухай" 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлэх журам"-ын дагуу үнэлгээ хийж БОУАӨЯ-ны ХҮАГ-т тайлагнасан.	100
Зорилт 3.Санхүү, хөрөнгө оруулалтын төсвийн төсөл боловсруулах хэрэгжүүлэх								
5	Арга хэмжээ 3.1.Төсвийн шууд захирагчийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан гаргах			Санхүүгийн тайлан-2	2	Төсвийн шууд захирагчийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд нь чанартай гаргаж, аудит хийлгэж, харьяалагдах дээд шатны төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлж нэгтгүүлсэн байна.	Усны газрын 2024 оны төсвийн гүйцэтгэл санхүүгийн тайланг хуулийн хугацаанд гаргаж 2024 оны 01 сарын 20 өдрийн 01/33 тоот албан бичгээр Үндэсний аудитын газарт хүргүүлж, и-тайланд шивж тайлагнасан байна. Аудит хийсэн санхүүгийн тайланг 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 01/99 тоот албан бичгээр БОУАӨЯ-аманд хүргүүлж баталгаажуулсан. Усны газрын 2024 оны төсвийн шууд захирагчийн төсвийн гүйцэтгэл санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраар аудит хийлгэсэн.	100

6	Арга хэмжээ 3.2.Агентлагийн хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах			Хэрэгжилтийн хувь	93	Холбогдох хууль тогтоомжийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж, хэрэгжилтийг 40-өөс доошгүй хувьтай хангаж ажилласан байна.	2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөөг батлуулсан. 2025 онд Усны нөөц, нуур, гол мөрний менежмент хөтөлбөрт 13 ажил тусгаснаас 2,790,000.0 төгрөгийн 3 ажлын тендерийг tender.gov.mn шивж оруулан, баталж зарласан байна. 2024 оны худалдан авах ажиллагааны үлдэгдэл 490,839.3 төгрөгийн 3 ажлууд нь "Шинжээч, шүүмжлэгч томилох тухай" БОУАӨЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2025.01.08-ны өдрийн А/02 дугаар тушаалаар Говь-Алтай аймгийн Төгрөг сумын төвийн ус хангамжийн нөөцийг тогтоох эрэл хайгуулын ажлын үр дүнгийн тайлангийн шүүмжлэгчдээр зөвлөх инженер, доктор З.Цэрэндорж, зөвлөх инженер Ц.Алтангэрэл нарыг томилж, шүүмжлэгчийн дүгнэлт гаргуулж, "Булган аймгийн Баяннуур сумын Баян нуурыг сэргээх төслийг хэрэгжүүлэх" ажлыг 2025 оны 03 сард ажлыг эхлүүлж, Усны барилга байгууламж барьж буй газарт халиа маш ихээр үүсэж, усанд автсан байсан тул гэрээт ажлыг газар дээр нь үргэлжлүүлэх хугацаа хойшлогдсон. "Эрээн нуурыг сэргээх" ажлын урсац тохируулах, халиах барилгын туршилт тохируулгын ажил 06 дугаар сарын 15-аас эхлэхээр хүлээгдэж байгаа үе шаттайгаар явагдаж байна. Мөн Дэлхийн усны өдөр, Хилийн усны хэлэлцээр, Усны нөөцийн зөвлөлийн хурал зохион байгуулах 929,646.1 төгрөгийн 7 ажлаас 365,176.5 төгрөгийн зардал гарч 57.7%-ийн гүйцэтгэлтэй байна. 2025 онд Худалдан авах ажиллагааны А3 гэрчилгээ авах сургаалтанд Усны газраас 13 ажилтан суралцаж үүнээс 8 ажилтан А3 гэрчилгээ авсан байна. Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл 52 хувьтай байна.	100
7	Арга хэмжээ 3.3.Агентлагийн ажилчдын цалин, тэтгэмжийг бодож олгох, нийгмийн даатгалын шимтгэл, хүн амын орлогын албан татварын тайлангуудыг тайлагнах			Тайлангийн тоо	24	Агентлагийн ажилчдын цалин, тэтгэмжийг бодож олгох, нийгмийн даатгалын шимтгэл, хүн амын орлогын албан татварын тайлангуудыг сар бүрд хугацаанд нь тайлагнасан байна.	2025 онд тус газрын албан хаагчдын 1-6 дугаар сарын цалинг сар бүрийн 10, 20-нд төрийн албан хаагчдын цалингийн Payroll программд 2 удаа бодолт хийж газрын дарга, ахлах нягтлан бодогчоор тухай бүр хянан шалгуулаж албан хаагчдын цалинг хугацаанд нь олгож ажиллалаа. 2025 оны 1-6 дугаар сарын Нийгмийн даатгалын цаасан болон цахим тайланг ахлах нягтлан бодогчоор хянуулан сар бүрийн 4-ний дотор Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэст хуулийн хугацаанд нь хүргүүлж баталгаажуулан ажилласан. Мөн Баянгол дүүргийн Татварын хэлтэст ХХОАТ-ын улирлын тайлангаа цаг хугацаанд нь илгээж баталгаажуулсан болно. 2025 оны байдлаар 6 удаа нийгмийн даатгалын тайлан гаргаж 37 албан хаагчаас 06-хүүхэд асрах чөлөөтэй эх-1, тэтгэврийн насны албан хаагч 3, албан хаагч 33 ажилчдын цалингаас даатгуулагч болон ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг тооцон ажилласан.	100
8	Арга хэмжээ 3.4.Төрийн өмчийн эд хөрөнгийн анхан шатны баримтын бүрдэл, хөрөнгийн хөдөлгөөн өөрчлөлтийн тайлан, мэдээг гаргах			Тайлангийн тоо	12.00	Үндсэн хөрөнгөд гарсан хөдөлгөөн, өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн дэлгэрэнгүй бүртгэлд бүрэн тусгаж, анхан шатны баримтуудын бүрдлийг бүрэн хангасан тайланг сар тутам гаргаж танилцуулсан байна.	2025 онд тус газрын 1-6 сард хөрөнгөд гарсан хөдөлгөөн, өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн дэлгэрэнгүй бүртгэлд бүрэн тусгаж, анхан шатны баримтуудын бүрдлийг бүрэн хангасан тайланг сар тутам гаргаж ажилласан.	90

9	Арга хэмжээ 3.5.Байгууллагын эд хөрөнгийн тооллого, актлах хөрөнгө, балансаас балансад шилжүүлэх ажлыг хуулийн хугацаанд чанартай зохион байгуулах			Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь		Өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хөрөнгийн хөдөлгөөнтэй холбоотой асуудлыг оруулж шийдвэрлүүлэн, гарсан шийдвэрийн дагуу холбогдох ажил арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна.	Усны газраас Сав газрын захиргаанд 6 нэр төрлийн 18 ширхэг нийт 18,662,500 /Арван найман сая зургаан зуун жаран хоёр мянга таван зуун төгрөг/ бүхий үндсэн хөрөнгийг балансаас балансаас шилжүүлэх, үндсэн хөрөнгийн бүртгэлтэй, акталж данснаас хасах 10 нэр төрлийн 15 ширхэг нийт 11,132,594.83 / Арван нэг сая нэг зуун гучин хоёр мянга таван зуун ерэн дөрвөн төгрөг наян гурван мөнгө/, үндсэн хөрөнгөнд бүргэлтэй ашиглалтын хугацаа дууссан, дахин ашиглах боломжтой ашиглалтын хугацаа сунгах 16 нэр төрлийн 22 ширхэг 254,351,534/ Хоёр зуун тавин дөрвөн сая гурван зуун тавин нэгэн мянга таван зуун гучин дөрвөн төгрөг/ үндсэн хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцүүлэн дүгнэлт гаргуулахаар хүлээгдэж байна.	50
10	Арга хэмжээ 3.6.Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг үндэслэн батлагдсан төсвийг үр ашигтай зориулалтын дагуу зарцуулах, төрийн өмчийн хөрөнгийн бүртгэл, төсвийн хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлэх			Хяналт тавин ажилласан байдал, хувиар		Төсвийг үр ашигтай зарцуулж, зөрчил дутагдалгүй ажилласан байна.	Төсвийн тухай хуулийн 8.8.1.төсвийн шууд захирагч төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 02-ны дотор харьяалагдах төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэх гэж заасны дагуу Усны газрын 2025 оны 1-5 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ хуулийн хугацаанд БОАЖЯ-ны Төрийн санд хүргэгдэж удирдлагуудыг мэдээллээр ханган ажилласан. Байр ашиглалт, дотоод томилолт, хангамж бараа материал, эд хогшил урсгал засвар, дотоод томилолт, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг батлагдсан сарын хуваарийн дагуу хянаж баталгаажуулан төрийн санд гүйлгээ хийж Усны газрын санхүүгийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллаа. 2025 оны 1-5 сарын батлагдсан төсөв 1.961,5 сая төгрөг үүнээс 1.022,4 сая төгрөгийг зарцуулсан байна.	100
11	Арга хэмжээ 3.7.Олон улсын болон улсын секторын нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн нягтлан бодох бүртгэлийн тогтолцоог хэрэгжүүлэх			Стандартын хэрэгжилт хангагдсан байдал, хувиар		Нягтлан бодох бүртгэлийг стандартад нийцүүлэн зохион байгуулсан байна.	НББ-ийн ОУСтандартын дагуу санхүү бүртгэлийг хөтлөн, улсын секторын НББ-ийн стандартад нийцсэн санхүүгийн CTSsystem 6.5 программыг НББүртгэлдээ ашиглаж байна.	100
12	Арга хэмжээ 3.8.Төсөв санхүүтэй холбоотой хуулийн хэрэгжилтийг зохион байгуулж төсвийн хэмнэлтийн горимыг хэрэгжүүлэх, төсөв санхүүгийн сахилга батыг сайжруулах ажлыг зохион байгуулах			Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байдал, хувиар		Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт хангагдсан байна.	Усны газрын 2025 оны 1-5 сарын байр ашиглалтын зардал 12,8 сая, хангамж бараа материалын зардал 22,4 сая, нормативт зардал 54,7 сая, эд хогшил урсгал засварын зардал 18,1 сая төгрөгийн хэмнэлттэй байна. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 804,0 сая төгрөгийн хэмнэлттэй байгаа нь төндөрийн ХАА-ны шалгаруулалт дуусаагүй эхний санхүүжилт олгогдоогүйтэй холбоотой хэмнэгдсэн.	100
Зорилт 4. Үйл ажиллагааны менежментийг боловсронгуй болгох, хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, чадавхыг бэхжүүлэх								
13	Арга хэмжээ 4.1.Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн удирдлагын системд хүний нөөцийн мэдээллийг оруулах, боловсон хүчний шилжилт хөдөлгөөнийг тогтмол шуурхай зохион байгуулах.			Хүний нөөцийн удирдлагын системийн мэдээллийг гүйцэтгэлийн хувь	100	Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн удирдлагын системд хүний нөөцийн мэдээллийг шинэчлэн боловсон хүчний шилжилт хөдөлгөөнийг тухай бүрд нь шуурхай зохион байгуулж, гүйцэтгэлийн 100 хувь хангаж ажилласан байна	Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн удирдлагын системд хүний нөөцийн мэдээллийг тухай бүрд нь шинэчлэн оруулж, боловсон хүчний 16 шилжилт хөдөлгөөнийг тухай бүрд нь шуурхай зохион байгуулж, гүйцэтгэлийн 100 хувь хангаж ажилласан байна	100

14	Арга хэмжээ 4.2.Албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх			Хэрэгжилтийн хувь	95.8	Албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж, батлуулах, 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэл 40 хувиас доошгүй байна	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор 2025 оны төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар батлан хэрэгжүүлж ажилласан бөгөөд Хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах зорилтын хүрээнд 3 арга хэмжээ, Албан хаагчдын ажлын байрны нөхцөл, хангамжийг сайжруулах, үр дүнтэй ажиллах нөхцөл бололцоог хангах зорилтын хүрээнд 4 арга хэмжээ, Албан хаагчдын амьдралын нөхцөлийг сайжруулах, тусламж дэмжлэг үзүүлэх хүрээнд 7 арга хэмжээ, Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, бие бялдрыг хөгжүүлэх зорилтын хүрээнд 3 арга хэмжээ төлөвлөн зохион байгуулж нийт хэрэгжилтийн дундаж үзүүлэлтээр 93.5 хувийн гүйцэтгэлтэй байна.	50
15	Арга хэмжээ 4.3.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Авлигын эсрэг хууль тогтоомжийг мөрдүүлэх, ёс зүйтэй, шударга ажиллах талаар ойлголт, хандлага, соёлын өөрчлөлт бий болгоход чиглэсэн ажлын байран дахь сургалтыг зохион байгуулна.			Зохион байгуулсан сургалтын тоо	4	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээгээр 2 удаа танилцуулга, сургалт хийсэн байна.	Авлигатай тэмцэх газартай хамтран 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр нийт албан хаагчдад авлигаас урьдчилан сэргийлэх болон ХАСХОМ-ийг бөглөх журмын талаар сургалт орж, "Шударга байдлын үнэлгээ ба авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө" 2024 оны үр дүн танилцуулах хэлэлцүүлэгт 1 албан хаагч, Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургагч багш бэлтгэх сургалтад 2025.03.27-28-ны өдрүүдэд 4 албан хаагч оролцсон. "Эрдэнэжамц сан" ТББ-тай хамтран 2025.04.10-ны өдөр нийт албан хаагчдад сэтгэл зүй болон ёс зүйн талаарх сургалт орж зөвлөгөө өгсөн.	100
16	Арга хэмжээ 4.4.Авлигын эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх хүрээнд "Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө"-г боловсруулж хэрэгжүүлэх			Төлөвлөгөөний гүйцэтгэлийн хувь	81.0	"Авлигын эсрэг үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөө"-г боловсруулж, эхний хагас жилийн байдлаар 80-аас доошгүй хувь хэрэгжүүлэн ажилласан байна.	2025 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулан цахимаар Авлигатай тэмцэх газарт хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тайлангийн хугацаа болоогүй. Мөн "Шударга байдлын үнэлгээ-2024" судалгааны тайлантай танилцан "Байгууллагын шударга байдлын үнэлгээг сайжруулах" 3 зорилтын хүрээнд 7 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг боловсруулан 2025 оны 05 дугаар сарын 10-ны өдөр газрын даргаар байтуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөнд заагдсан арга хэмжээнүүдийн явцын зорилтод түвшинд хамаарах гүйцэтгэлийг гаргаж дүгнэхэд 84.2 хувийн гүйцэтгэлтэй байна.	100

Зорилт 5. Олон Улсын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, хилийн усыг ашиглах, хамгаалах хэлэлцээрийг хэрэгжүүлэх

17	Арга хэмжээ 5.1.Усны нөөцийг бохирдож хомстохоос хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, олон улсын хамтын ажиллагаа, олон улсын гэрээ конвенц, хилийн усыг хамгаалах, ашиглах Засгийн газар хоорондын хэлэлцээр, Хилийн усны ажлын хэсэг, шинжээчдийн багийн уулзалтыг зохион байгуулах	248.9	Улсын төсөв	Хамтарсан шинжээчдийн багийн протокол Бүрэн эрхт төлөөлөгчдийн зөвлөгөөний протокол	Жил бүр тогтмол зохион байгуулдаг	Бүрэн эрхт төлөөлөгчдийн хэлэлцээрийг зохион байгуулж, протокол-1 үйлдсэн байна.	Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын Хилийн усны хамтарсан комиссын Есдүгээр хуралдааныг 2025 оны 03 дугаар сарын 12-13 -ны өдрүүдэд зохион БНХАУ-ын Бээжин хотноо зохион байгуулж, Монгол Улсын талаас БОУАӨЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Э.Баттулгаар ахлуулсан 10 төлөөлөгч оролцож ажилласан. Нийт зарцуулсан төсөв 58.760.520 төгрөг	100
----	--	-------	-------------	--	-----------------------------------	--	--	-----

[illegible]

21	Арга хэмжээ 7.1.Олон нийтийн устай холбоотой хэвшмэл ойлголтыг өөрчлөх, хууль тогтоомжтой холбоотой асуудлыг түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулах	330.0	Улсын төсөв	-“Цэнхэр алт” үндэсний чуулган зохион байгуулах. - Иргэд, олон нийтийг мэдээллээр хангах ажил зохион байгуулах	2024 онд “Цэнхэр тууз” аяныг зохион байгуулсан	Олон нийтийн хамтын ажиллагааг өргөжүүлж, усны тухай хууль, тогтоомжуудыг сурталчлах хүрээнд “Дэлхийн усны өдөр”-ийг тохиолдуулан сарын аян зохион байгуулах	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Усны газар, Ерөнхийлөгчийн Тамгын газар хамтран усны нөөцийг хамгаалах, зүй зохистой ашиглах, салбарын бодлого, хууль эрх зүйг шинэчлэх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилготой “Цэнхэр алт” үндэсний хоёрдугаар чуулганыг Төрийн ордонд зохион байгуулав. Чуулганы өмнөх үйл ажиллагаанууд 1.Оюутны эрдэм шинжилгээний бага хурал 2.“Ус-Хөгжлийн түлхүүр” сэдвээр зохиогдож, шилдэг 10 илтгэлийг шалгаруулав. Ахлах ангийн сурагчдын илтгэлийн уралдаан “Өөрчлөлтийг хурдасгая” сэдвээр 58 оролцогчоос 3 шилдгийг тодруулсан. Үндэсний чуулганд нийт 13 улсын Элчин сайд, төрийн болон ТББ, судлаачид, нийт 927 төлөөлөгч оролцож усны салбарын тулгамдсан асуудлуудаар илтгэл тавьж хэлэлцүүлсэн. Чуулганаас нийт 4 чиглэл, 19 заалт бүхий зөвлөмжийг гаргасан. Чуулганыг олон нийтийн мэдээлэлд өргөн хүрээтэй хүрсэн (шууд дамжуулалт, нийтлэл, шторкууд) хүргэж 40,000 гаруй үзэгч, олон нийтэд хүрсэн байна. Нийт зарцуулсан төсөв 285.065.000 төгрөг	100
22	Арга хэмжээ 7.2.Агентлагийн үйл ажиллагаанд хуулиар хориглоогүй мэдээллийг олон нийт, иргэдэд ил тод, нээлттэй байлгах, мэдээлэл авах эрх тэгш боломжоор хангах			Үнэлгээний хувь	shilen.gov.mn системийн хэрэгжилт 20 хувьтай	Цахим сайтуудад оруулах мэдээллийг тухай бүр бүрэн оруулж shilen.gov.mn системийн үнэлгээг 50 хувьд хүргэх	Мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу байгууллагын цахим хуудас болон Төрийн нээлттэй өгөгдлийн системд байршуулах нээлттэй мэдээлэл болон нээлттэй өгөгдлийг тогтоосон хугацаанд олон нийтэд ил тод мэдээлсэн байдалд хяналт тавьж, дотоод аудит хийсэн. “Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор баталсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”, 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу Агентлагийн 2024 болон 2025 оны эхний хагас жилийн нээлттэй мэдээлэл нийтэлсэн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж БОУАӨЯ-ны ХҮАГ, Авлигатай тэмцэх газарт тайлагнасан. Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 3 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын хүрээд мэдээлэл хариуцагчийн цахим хуудсанд тогтмол байршуулж байх нээлттэй мэдээллийг нийтэлж байх тухай тушаалыг төслийг боловсруулж Усны газрын даргын тушаалаар батлуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.	100
23	Арга хэмжээ 7.3.Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавьж ажиллах			shilendans.gov.mn цахим системийн хэрэгжилтийн хувь		Мэдээллийг 100 хувь хугацаанд нь оруулсан байна	2025 оны 06 дугаар сарын 10-ны өдийн байдлаар Шилэн дансны цахим системд төсөв, түүний гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт болон бусад мэдээлэлтэй холбоотой 16 төрлийн 68 мэдээлэл оруулахаас 3 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан байна.	90

24	Арга хэмжээ 7.4.Сав газрын талуудын оролцооны зөвлөлүүдийн гишүүдийг чадавхжуулах, мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх сургалтыг үе шаттай зохион байгуулах, салбарын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, сав газрын захиргаадыг удирдлага, зөвлөмжөөр хангах			Төлөвлөсөн арга хэмжээний гүйцэтгэлийн хувь	-	Сав газрын захиргаадын хамтын ажиллагааг өргөжүүлж, сав газрын захиргаадыг мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан байна.	1.Усны тухай хуулийн хэрэгжүүлэхэд Сав газрын захиргаадын мэргэжилтнүүдийг дүгнэлтийг цахим болсонтой холбогдуулан мэргэжил арга зүйн сургалтыг зохион байгуулж, нийт 90 орчим албан хаагчид оролцсон. 2.Буйр нуур-Халх голын, Галба-Өөш-Долсоодын говийн, Дэлгэрмөрөн-Шишхэд голын сав газрын талуудын оролцооны хурлаар орон нутагт очиж ажиллах үеэр "Нэг сум-Нэг нуур" 333 нуур хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутгийн мэргэжлийн байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл, нутгийн иргэдэд хөв цөөрмийн талаарх ач холбогдлыг таниулах сургалт, судалгааг танилцуулсан ажилласан.	100
Зорилт 7.Үйл ажиллагааны тасралтгүй, хүртээмжтэй хурдан шуурхай байдлыг хангаж, үйл ажиллагааг цахимжуулах.								
25	Арга хэмжээ 8.1.Аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс ирүүлсэн албан бичиг, өргөдөл, гомдол хүсэлтийн хариуг хуулийн хугацаанд түргэн, шуурхай шийдвэрлэх ажлын үр дүнг сайжруулах.			Ирүүлсэн албан бичиг, хүсэлтийг түргэн шуурхай шийдвэрлэх хугацаа	Хууль, тогтоомжид зааснаар 7-30 хоногт шийдвэрлэнэ	Дунджаар 15 хоног	2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар ирсэн бичиг 482, явуулсан бичиг 328, өргөдөл, гомдол бүхий 23 албан бичгийн цахим архив үүсгэсэн. Үүнээс ирсэн 346 албан бичгийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, 136 албан бичиг хариу өгөхөөр судлагдаж байгаа буюу нийт ирсэн албан бичгийн шийдвэрлэлт 71,2 хувьтай байна. Нийт албан бичгийн хугацаатай 114 албан бичгийг шийдвэрлэлтийг хугацаагаар нь авч үзвэл 13,8 хоногт шийдвэрлэсэн байна.	100
26	Арга хэмжээ 8.2.Усны мэдээллийн нэгдсэн систем /ewater.mn/-ийг хөгжүүлж усны салбараас үзүүлдэг төрийн үйлчилгээг цахимжуулах			Цахим системээр үзүүлж байгаа үйлчилгээний хувь	Усны мэдээллийн нэгдсэн систем /ewater.mn/-ийг шинээр нээсэн	"Усны мэдээллийн нэгдсэн систем"-ийн хөгжүүлэх ажлыг зохион байгуулж нийт Сав газрын захиргаа, байгаль орчны газруудыг холбох ажлыг зохион байгуулж улсын хэмжээнд 50-иас доогүй хувьд цахим болгосон байна	"Усны мэдээллийн нэгдсэн систем"-ийн хөгжүүлэх ажлыг зохион байгуулж нийт Сав газрын захиргаа, байгаль орчны газруудыг холбох ажлыг зохион байгуулж улсын хэмжээнд 50-иас доогүй хувьд цахим болгосон байна	100
27	Арга хэмжээ 8.3. Байгууллагын дотоод, гадаад сүлжээ, тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангаж, мэдээлэл, технологийн асуудлыг тухай бүрд шийдвэрлэж ажиллана.			Хэвийн үйл ажиллагаа хангагдсан байдал	-	Байгууллагын гадаад, дотоод цахим сүлжээний хэвийн ажиллагаа хангагдсан байна.	Тагнуулын Ерөнхий Газраас ирсэн албан бичгийн дагуу улсын онц, чухал байгууллагын жагсаалтад багтаж "Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээ"-д холбогдох шаардлагатай болсон тул техникийн нөхцөлийг бүрдүүлэн холболтыг хийв. Байгууллага өөрийн албан хэрэгцээнд ашигладаг компьютер, дотоод сүлжээний бүрэн шинэчлэлтийг хийв. СТС компанийн инженерүүд сүлжээний ажлыг ажлын 5 өдөрт хийж дуусгалаа. Ингэснээр сүлжээний найдвартай байдал сайжрах болно.	100

28	Арга хэмжээ 8.4.Нэгжийн албан хаагчдад мэдээллийг шуурхай хүргэх, бусад нэгжтэй мэдээлэл солилцох, хамтран ажиллах, ажлын уялдааг зохион байгуулах, хяналт тавих			Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь	-	Байгууллагын үйл ажиллагааны чанарын үзүүлэлт дээшилсэн байна.	Нэгжийн албан хаагчдыг мэдээллээр хангах хүрээнд Засгийн газрын тогтоол, хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын захирамжийг ERP систем болон байгууллагын дотоод цахим шуудангаар 5 удаа мэдээллэж, Агентлагийн дарга болон хэлтсийн даргаас өгсөн чиг үүргийн талаарх мэдээллийг байгууллагын цахим системд, хэлтсийн дотоод цахим шуудангаар тогтмол мэдээлэл хийсэн байна. Түүнчлэн агентлагийн даргаас өгсөн үүргийн дагуу яамнаас ирүүлсэн мэдээлэл болон даргаас өгсөн үүргүүдийн талаарх бүртгэл хөтлөн хэрэгжилтийн талаар 5 удаа танилцуулан ажиллаж, албан хаагчдын ажлын үр дүнг сайжруулах хүрээнд 6 албан хаагчийн ажлын байрны шилжилт хөдөлгөөн хийн ажиллуулсан байна.	100
29	Арга хэмжээ 8.5.Байгууллага, нэгжид хуваарилагдсан баримт бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавих, албан хэргийг стандарт, зааврын дагуу хөтлөх, архивын нэгж бүрдүүлэх ажлыг зохион байгуулах			Архив, албан хэрэг хөтлөлтийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь	-	Архив, албан хэрэг хөтлөлтийн хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна	Ирсэн бичиг-218 /үүнээс шийдвэрлэсэн: 203, судалж байгаа буюу хугацаа болоогүй бичиг-15 /, явсан бичиг-123, өргөдөл-23 /үүнээс шийдвэрлэсэн: 20, судалж байгаа буюу хугацаа болоогүй-3/ байна.	70
Нийт хэрэгжүүлэх арга хэмжээний төсөв /сая төгрөг/		7,168.5		Нийт 7 зорилтын хүрээнд 31 арга хэмжээг хэрэгжилт				90.3

Хавсралтаар: Удирдлага, санхүүгийн хэлтсийн дарга Д.Сайханжаргалын мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЯНАСАН: Төсвийн Шууд захирагч

УСНЫ ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙН

ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

3.БАТБАЯР

2025 оны сарын

ТӨЛӨВЛӨГӨӨГ ТАЙЛАГНАСАН:

УДИРДЛАГА, САНХҮҮГИЙН

ХЭЛТСИЙН ДАРГА

Д.САЙХАНЖАРГАЛ

2025 оны сарын

**УДИРДЛАГА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Д.САЙХАНЖАРГАЛЫН 2025 ОНЫ МЭДЛЭГ,
УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ**

д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлти йн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин /эхний хагас жил/	Хүрсэн түвшин /биелэлт/		
	1	2	3	4	5	6	7
1	Арга хэмжээ 1.Засгийн газрын 2020 оны 3 дугаар сарын 18-ны 96 дугаар тогтоолоор баталсан "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III"-ын хүрээнд Монгол бичиг сурах	Мэдлэг чадвар дээшилсэн байна.	Монгол бичгийн анхан шатны мэдлэг эзэмшсэн	Удирдлагын академи болон байгууллагаас зохион байгуулсан цахим сургалтад хамрагдаж дунд шатны мэдлэгийг эзэмшсэн байна	"Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III"-ын хүрээнд Монгол бичиг сурах ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор Удирдлагын академиас цахимаар зохион байгуулж байгаа Монгол бичгийн цахим сургалтын дунд шатны сургалтыг төгссөн.	03	100
2	Арга хэмжээ 2.Салбарын яам, Төрийн албаны зөвлөл, Удирдлагын академи, бусад байгууллагаас зохион байгуулсан сургалтад хамрагдаж мэдлэг ур чадвараа дээшлүүлсэн байна.	Мэдлэг чадвар дээшилсэн байна.	-	Зохион байгуулагдсан сургалтуудад тухай бүрд нь бүрэн хамрагдсан байна.	Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан авлигаас урьдчилан сэргийлэх болон ХАСХОМ-ийг бөглөх журмын талаар сургалтад хамрагдсан. ЗГХЭГ-аас Төрийн ордонд зохион байгуулсан Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан "Хяналт шинжилгээ, үнэлгээ хийх журам"-ын талаарх сургалтад хамрагдсан.	01-05	100

УДИРДЛАГА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Д.САЙХАНЖАРГАЛЫН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН
ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС
(Удирдах албан тушаалтан буюу нэгжийн дарга)

Байгууллагын нэр: Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газар
Нэгжийн нэр: Удирдлага, санхүүгийн хэлтэс

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн түвшин	Нийт оноо (70 оноо)
1	2	3	4
1.	Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	95.0	66.5

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Арга хэмжээ 1.Засгийн газрын 2020 оны 3 дугаар сарын 18-ны 96 дугаар тогтоолоор баталсан "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III"-ын хүрээнд Монгол бичиг сурах	100	15
2.	Арга хэмжээ 2.Салбарын яам, Төрийн албаны зөвлөл, Удирдлагын академи, бусад байгууллагаас зохион байгуулсан сургалтад хамрагдаж мэдлэг ур чадвараа дээшлүүлсэн байна.	100	15
Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо			15,0

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

д/д	Үзүүлэлт	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Хандлага, ёс зүй	15
2.	Удирдан зохион байгуулах	15
3.	Асуудал шийдвэрлэх	15
4.	Манлайлах	15
5.	Багаар ажиллах	15
6.	Харилцаа	15
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)		
6.	Мэргэжлийн ур чадвар 1.	-
7.	Мэргэжлийн ур чадвар 2.	-
8.	Мэргэжлийн ур чадвар 3.	-
Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо		15

4. Гүйцэтгэлийн үнэлгээ

д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт.)	66,5
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт (Төсвийн шууд захирагчийн үнэлгээ)	15,0
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Төсвийн шууд захирагчийн үнэлгээ)	15,0
4.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	-

Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо	96,5
--	--------------------

Үнэлгээ өгсөн: Төсвийн шууд захирагч

УСНЫ ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



/З.БАТБАЯР/

2025 оны 06 сарын 19

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн: Нэгжийн дарга

УДИРДЛАГА, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

/Д.САЙХАНЖАРГАЛ/

2025 оны сарын